“ГЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 4-р сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

Хурал 2026 оны 4-р сарын 10-ны өдөр УБ хот, БГД, 25-р хорооны нутаг дэвсгэрт байрлах компанийн өөрийн байрны 3 давхарт байрлах хурлын танхимд 15.00 цагаас танхимаар болж өнгөрлөө. Хурлын ирцийн бүртгэлийг 2026 оны 02-р сарын 11-ний өдрийн ТУЗ-өөс томилогдсон тооллогын комисс явууллаа. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн нээж үг хэллээ.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа биечлэн оролцож байгаа хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэж байна. Хурлын танхимд хувьцаа эзэмшигч нар цугларсан тул өнөөдрийн хурлын дэгийг танилцуулья. Үүнд:

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хэлэлцүүлэгч	Хурлын шийдвэр
1	Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах	5 минут	Хурал зохион байгуулах комисс	Хурлын тэмдэглэлд оруулах
2	Хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Хурлын тэмдэглэлд оруулах
3	Хурлын тооллогын комиссын дүнг танилцуулах	5 минут	Тооллогын комисс	Тогтоолоор батлах
4	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай	10 минут	Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
5	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт	10 минут	Аудитын хорооны дарга Д.Туяа	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	10 минут	Хувьцаа эзэмшигчид	
6	“Компанийн дүрэм”-д өөрчлөлт оруулж батлах тухай	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
7	Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай	10 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
8	Компанийн 2026 оны үйл ажиллагааны зорилтын тухай		Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	10 минут	Хувьцаа эзэмшигчид	
9	Компанийн 2026 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай		ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	10 минут	Хувьцаа эзэмшигчид	

Дэгийн дагуу өнөөдрийн хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай мэдээллийг та бүхэнд танилцуулья. Манай "Компанийн дүрэм"-ийн 7.5-д "Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга"-аар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга байна гэсэн заалт, мөн ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 11-ний өдрийн "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай" 4 тоот тогтоолын дагуу хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Оюунсүрэн миний бие удирдан явуулна. Хурлын дэгийн дагуу хэлэлцэж буй асуудал бүр дээр хувьцаа эзэмшигчид та бүхэн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд хурлын ирцийн талаарх мэдээллийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга О.Энхжаргал: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. ТУЗ-ийн шийдвэрийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс нь "Компанийн тухай хууль"-ийн 67.3.1-д заасны дагуу өнөөдрийн хурлын ирцийг танилцуулья. Өнөөдрийн хуралд биечлэн оролцож байгаа 24,897,739 саналын эрхтэй 21 хувьцаа эзэмшигчид, мөн хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42,530,145 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч байна. Брокер дилерийн компаниудаас саналын хуудас ирүүлээгүй байна. 15 цаг 20 минутын байдлаар хурлын ирц 85.8 хувьтай байна. "Компанийн тухай хууль"-ийн 69.1-р заалт, "Компанийн дүрэм"-ийн 7.4-р заалтанд заасны дагуу нийт саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг бүртгэж байгаа тооллогын комисс хурлын ирцийн талаарх мэдээллийг танилцууллаа. Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, тооллогын комиссын тогтоолын дагуу 85.8%-н хурлын ирцийг хангалттай гэж үзээд, хурал нээснийг мэдэгдэж байна. Ингээд дэгийн дагуу хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Хэлэлцсэн 1-р асуудал: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилье. Ингээд миний бие та бүхэнд компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх мэдээллийг та бүхэнд танилцуулья. Хурлын материалд мөн хавсаргагдсан болно.

Манай компани нь өнгөрсөн 2025 онд 16 ажилтан, ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж, батлагдсан орлого, зарлагын төсөв төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:
1. Хүний нөөцийн талаар:

- Компанийн ажилтан ажиллагсадтай 2025 оны гэрээг шинэчлэн байгуулж, ажиллагсдын ажлыг "Ажилтны үнэлгээний хуудас"-аас улирал тутамд дүгнэж байна.
- Ажиллагсдын ээлжийн амралтыг батлагдсан хуваарийн дагуу амраасан. Мөн сар бүр ажилтан ажиллагсдын ажил, амралтын хуваарийг баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
- Компанийн нягтлан бодогч, мэргэжилтэн нар нь өөрсдийн хариуцсан ажилтан ажиллагсдад өдөр бүр ажил хэргийн мэдээ, мэдээллийг өгч, харилцан зөвшилцөх зарчмаар хамтран ажиллаж байна. Мөн гүйцэтгэх захирал сар бүр ажиллагсдын хурлыг тогтмол хийж, шаардлагатай мэдээллийг өгч байна.
- Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу хуваарьт ажлуудыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.

2. Түрээслэгчдийн талаар:

- Гүйцэтгэх удирдлагын баг нь худалдааны төвийн түрээслэгчидтэй байгуулсан 2025 оны түрээсийн гэрээний гүйцэтгэлийн явцын үнэлгээг түрээслэгч тус бүртэй хамтран дүгнэж, улмаар 2026 оны 1-р сарын түрээсийн төлбөрт
  - ✓ 150 түрээслэгчид 91-ээс дээш оноо авч 10%-ийн хөнгөлөлтийг
  - ✓ 55 түрээслэгчид 71-90 хүртэлх оноо авч 5%-ийн хөнгөлөлтийг эдэлсэн болно.
- "Реха мед" эмнэлэгтэй хамтран түрээслэгчид болон ажиллагсдад зориулсан эрүүл мэндийн өдөрлөгийг 2025 оны 11-р сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Тус эмнэлгийн зүгээс эмэгтэйчүүдийн эмчийн зөвлөгөө, хөхний мэс заслын эмчийн үзлэг, зөвлөгөө, сэргээн засах эмчийн зөвлөгөө, зөв хооллолтын талаарх зөвлөгөө, сахар, цусны даралтын үзлэг, оношлогоо зэргийг үнэ төлбөргүй үзүүллээ.
- "Монгол даатгал" ХХК-тай хамтран даатгалын ач холбогдол, даатгалын төрөл зүйл, даатгалын хамрах хүрээ болон даатгуулагчид учирсан аливаа хохирлыг хэрхэн барагдуулах талаарх мэдээ мэдээллийг танилцуулсан.
- "Худалдаа хөгжлийн банк", "Голомт банк", "Төрийн банк", "Капитрон банк"-тай хамтран түрээслэгчдэд зориулсан санхүүгийн өдөрлөгүүдийг зохион байгуулсан.
- Худалдааны төвийн түрээслэгчид, тэдгээрийн худалдагч туслах ажилтнуудад болон иргэдэд зориулан хэрэглээний халуун хүйтэн ус, тог цахилгааныг зөв зохистой ашиглах, хэмнэх талаарх таниулга сурталчилгааг тогтмол хийж байна.
- Худалдааны төвийн түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж байна. Мөн түрээслэгчдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг тухай бүр харилцан зөвшилцөх зарчмаар хамтран ажиллаж байна.

3. Галын аюулгүй байдлын талаар:
   - Онцгой байдлын газраас өгсөн шаардлагын хүрээнд компанийн "Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ"-г худалдааны төвийн түрээслэгч "Евро ази сервис" ХХК-иар хийж гүйцэтгүүллээ. Энэхүү үнэлгээнд гамшиг болох гал, газар хөдлөлт, үерийн үед учирч болох аливаа эрсдэлийг бууруулахад компанийн удирдлагын зүгээс ямар арга хэмжээг, хэрхэн авч ажиллах талаарх заавар зөвлөмжийг ирүүлсэн. Эдгээр заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж чадсан тохиолдолд аливаа гамшиг ослыг эрсдэл багатай даван туулах боломжтой юм.
   - Худалдааны төвийн түрээслэгч, тэдгээрийн худалдагч, туслах ажилтнуудад галын аюултай нөхцөл байдлаас хэрхэн урьдчилан сэргийлж ажиллах талаарх зөвлөгөө, мэдээллийг сар бүрийн захидлаар дамжуулан хүргүүллээ.
4. Харуул хамгаалалтын талаар:
   - Худалдааны төвийн зохицуулагч нарт хулгай, залилан, дээрэм тонуулаас урьдчилан сэргийлж ажиллах талаар зөвлөгөөг тогтмол өгч байна.
   - Худалдааны төвийн гадна, дотор талын хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг хангаж, тусгайлсан дэвтэрт тэмдэглэгээ хийж, эвдэрч гэмтсэн тохиолдолд тухай бүр засварлаж ажилласан.
5. Аж ахуйн засварын талаар:
   - Батлагдсан төсвийн хүрээнд худалдааны төвийг цахилгааны эх үүсвэрээр хангадаг байсан 10 000 квт-ын хос шугамыг шинэчилж солих ажлыг "Бадамлах хүч" ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүллээ. Ингэснээр цахилгааны найдвартай эх үүсвэртэй болж улмаар худалдааны төвийг хэвийн ажиллах боломжийг бүрдүүлсэн.
   - Худалдааны төвийн цэвэр, бохир усны тоолуурын баталгаат хугацаа дууссаныг шинэчлэн баталгаажууллаа.
6. Цэвэрлэгээ, үйлчилгээний талаар:
   - Худалдааны төвийн гадна болон дотор талд өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, түрээслэгч, худалдан авагчдад цэвэр цэмцгэр, ая тухтай орчныг бүрдүүлэн ажиллаж байна.

- Худалдааны төвийн хог хаягдлыг 7 хоног бүр ачуулж, улмаар гадна талбайд байрлах хогийн функерийг ариутган цэвэрлэж байна.
- "Хог хаягдлын тухай хууль"-ийн 10.2.10 дахь заалтын дагуу худалдааны төвийн эргэн тойрон дахь нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас мөсийг тухай бүр цэвэрлэж байна.
- Нийслэл болон БГДүүргээс зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан цэвэрлэгээ үйлчилгээнд ажиллагсдаа тогтмол оролцуулж, худалдааны төвийн ойр орчмын 50м хүртэлх нийтийн эдэлбэр газрыг байнга цэвэрлэж, оршин байгаа дүүрэг хорооныхоо өнгө үзэмжинд өөрсдийн хувь нэмрээ оруулж ажиллав.

7. Архив бичиг хэргийн талаар:
   - Өмнөх оны санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой баримтууд, түрээсийн гэрээ, ТУЗ, ХЭХуралтай холбоотой баримт материалуудыг үдэж, архивласан.
   - Түрээслэгч иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу түрээсийн тодорхойлолт, түрээс төлөлтийн тайлан зэрэг мэдээ мэдээллийг гарган өгч байна.
   - СЗХ, МХБирж болон бусад харилцагч байгууллагуудаас ирүүлсэн албан тоотуудыг бүртгэлжүүлж, холбогдох хариуг боловсруулан хүргүүлж байна.
8. Олон нийттэй харилцах талаар:
   - Компанийн www.hermescenter.mn, МХБ-ийн www.mse.mn цахим хуудсан дахь ТУЗ, ХЭХ болон компанийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг тогтмол шинэчилж байна.
   - Худалдааны төвийн түрээслэгчдэд сар бүрийн захидлаар дамжуулан тухайн сард хийгдсэн ажил үйлчилгээ, дараагийн сарын ажил амралтын өдөр, ажиллах цагийн хуваарь, худалдааны төвийн дотоод журам зэргийн талаарх мэдээ мэдээллийг тогтмол хүргүүлж байна.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээллийг танилцуулж дууслаа. Асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул Гүйцэтгэх захирал тайлангаа үргэлжлүүлэв.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Ингээд та бүхэнд санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд болон хувьцааны үнэ ханш, хувьцаа эзэмшигчид болон нэгдмэл сонирхолтой этгээдүүд, компанийн засаглалын талаар бэлдсэн дараах тайлан мэдээллүүдийг танилцуулья. Үүнд:

9. Санхүүгийн үйл ажиллагааны талаар:
   - Компанийн мөнгөн урсгалын тооцоог урьдчилан гаргаж, мөнгөн хөрөнгийн зохицуулалтыг тогтмол хийж, орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавин ажиллалаа.
   - Санхүүгийн тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох зохицуулагч байгууллагуудад тайлагнаж байна.
   - Улсад төлөх ёстой татвар хураамж, ашиглалтын болон бусад зардлуудыг цаг тухайд нь бүрэн төлж байна.
   - Худалдааны төвийн түрээслэгчдээс авах түрээсийн орлогыг тухайн сардаа багтааж бүрэн хураан авч, түрээсийн төлбөрийн үлдэгдэлгүй ажиллаж байна.
   - Ажиллагсдын ээлжийн амралтын нөхөн олговор, ХЧТА-ны тэтгэмж зэргийг цаг тухайд нь холбогдох хууль, журмын хүрээнд тооцон олгож байна.
   - Компанийн 2025 оны санхүүгийн тайланд "Си Эс Ай" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2 удаагийн хөндлөнгийн аудитын ажлыг хийлгэсэн. Хурлын материалын 9-13-р хуудаст аудитын компанийн дүгнэлт хавсаргагдсан тул та бүхэн танилцаарай.

Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдээс танилцуулья.

Нийт хөрөнгө 9,119.0 сая ₮ бөгөөд үүнээс:

- ✓ Эргэлтийн хөрөнгө 3,530.1 сая ₮
- ✓ Үндсэн хөрөнгө 3,300.4 сая ₮
- ✓ Биет бус хөрөнгө 2,288.5 сая ₮
- Эзэмшигчийн өмч хөрөнгө 8,694.7 сая ₮
- Татварын дараах цэвэр ашиг 2,073.5 сая ₮ байна.

2. Орлогын үр дүнгийн тухай : Компани 2025 онд 3,096.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллалаа. Борлуулалтын орлогын төлөвлөгөө 3,059.9 сая төгрөг байсантай харьцуулахад 101%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 36,3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Хадгаламжийн хүүний орлогын төлөвлөгөө 500,0 сая төгрөг байсан бол гүйцэтгэл 523,0 сая төгрөг болж төлөвлөгөөг 23,0 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллалаа. Компанийн 2025 оны нийт орлогын төлөвлөгөө 3,559.9 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 3,616.2 сая төгрөг болж төлөвлөгөөг 59,3 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллав.
3. Зардлын тухай: Компани 2025 онд 1,315.3 сая төгрөгийн зардалтай ажилласан. Зардлын төлөвлөгөө 1,427.5 сая төгрөг байсантай харьцуулахад 92%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 112,2 сая төгрөгөөр хэмнэн ажиллалаа.
4. Ашгийн тухай: Татварын дараах цэвэр ашиг 2,073.5 сая төгрөг гарсан. 2025 оны ашгийн төлөвлөгөө 1,919.1 сая төгрөг байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 154,4 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.
5. Ногдол ашгийн тухай: 2025 онд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 26 төгрөг 40 мөнгө гарсан. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн төлөвлөгөө 24 төг 43 мөнгө байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 1 төг 97 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан.

Компанийн сүүлийн 5 жилийн санхүүгийн үзүүлэлтүүдийг дараах графикуудаар харуулав.

График 1



6. Төсөвт төвлөрүүлсэн татвар, шимтгэлийн тухай: Манай компани нь 2025 онд нийт 848,4 сая ₮-ийн татварыг улсад төлсөн байна. Үүнд:
   - ААН-ийн ОАТатварт 219,2 сая ₮
   - НДШимтгэлд 113,6 сая ₮

- ХХОАТатварт 57,0 сая ₮
- НӨАТатварт 272,2 сая ₮
- ҮХЭХАТатварт 56,6 сая ₮
- Ногдол ашгийн татварт 118,0 сая ₮
- Газрын төлбөрт 11,8 сая ₮

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын татварын албанд төлсөн татварын хэмжээг харуулав.

График 2



Хурлын материалын 9-13-р хуудаснуудад санхүүгийн аудитлагдсан тайлан хавсаргагдсан байгаа тул хувьцаа эзэмшигчид та бүхэн уншиж танилцана уу. Дээрх тайлантай холбоотойгоор асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигч Г.Гансүх: Хурлын материалд дэлгэрэнгүй тайлагнасан байна. Мөн түүнчлэн миний хувьд "Гермес Центр" ХК-ийн санхүү, үйл ажиллагаа, засаглалтай холбоотой тайлан мэдээллүүдийг Монголын Хөрөнгийн Биржийн сайтаас цаг алдалгүй авч чаддаг учраас асуух асуулт алга байна. Гүйцэтгэх удирдлагын багийг сайн ажиллаж байна гэж миний хувьд дүгнэж байна.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Хувьцаа эзэмшигч Г.Гансүх танд баярлалаа. Бусад хувьцаа эзэмшигчдийн зүгээс санхүүгийн тайлантай холбоотой өөр асуух асуулт байна уу

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул гүйцэтгэх захирал компанийн засаглалын талаарх тайлан мэдээллийг танилцуулав.

"Гермес Центр" ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, компанийн нийт ажилтан ажиллагсад, түрээслэгч, үйлчлүүлэгч зэрэг талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилго, зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, чиглүүлэх, хянахад чиглэсэн бүтэц юм.

График 4



Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын талаар: "Гермес Центр" ХК нь "Компанийн тухай хууль", "Компанийн дүрэм", "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42,530,145 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч, хуралд биечлэн оролцож саналаа өгсөн 23,725,299 саналын эрхтэй 17 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн бөгөөд хурлын ирц 84.37%-тай байсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Туяа, хараат бус гишүүн Б.Алтангэрэл, ердийн гишүүн Б.Оюунцэцэг, Б.Амарсанаа, Ц.Түвшинжаргал, Д.Алтанчимэг нар биечлэн оролцлоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталсан тогтоол шийдвэр, хурлын материалыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн. Мөн хурлын мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн сайтанд байршуулсан болно.

<u>Компанийн засаглалын үйл ажиллагааны талаар</u>: "Гермес Центр" ХК нь Монгол Улсын хууль, холбогдох хууль тогтоомжууд болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тус тус баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг.

1. Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлуудыг (2025.02.14, 2025.05.29, 2025.08.28) холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг СЗХ болон МХБиржид хүргүүлсэн.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг 2025 оны 4-р сарын 4-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг холбогдох материалуудын хамт СЗХороо, МХБиржид тус тус хүргүүлсэн.

3. Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу 2024 оны сүүлийн хагас жил, 2025 оны эхний хагас жилийн ногдол ашгийн мөнгийг компанийн төв байр болон "Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв"-тэй гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд бүрэн байршуулан тараалаа.
4. СЗХорооноос баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу компанийн тухай бүр мэдээлэх мэдээллүүдийг МХБ-ийн www.mse.mn цахим хуудас, өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудсанд тус тус нийтэлж олон нийтэд мэдээллээ.
5. СЗХ болон МХБиржээс баталсан заавар журмуудыг өдөр тутамдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
6. Компанийн вэб сайт, мэдээллийн самбарны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, түрээслэгчдэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж ирлээ.
7. Компанийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн дунд хийсэн судалгааг ТУЗ-ийн хуралд танилцуулж ажилласан.
8. Бүртгэлтэй брокер дилерийн компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн гадаад дотоодын хувьцаа эзэмшигчдийг гүйцэтгэх захирал хүлээн авч холбогдох мэдээ, мэдээллийг өгч ажилласан.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн талаар: Монголын хөрөнгийн биржийн "Компанийн засаглалын кодексийг үнэлэх үнэлгээ"-ний аргачлалын дагуу 2025 оны 12-р сарын 30-ны өдрийн байдлаарх "Гермес Центр" ХК-ийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан

Хүснэгт 1

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2025. 12. 30-ны өдрийн байдлаар өөрийн	
			Үнэлсэн	Хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
Нэгдсэн дүн		**72**	**72**	**100%**

Хувьцаа эзэмшигчдийн талаар: Манай компани нь 2025 оны 9-р сарын 15-ны өдрөөр нийт 1091 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд дараах бүтэц, бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	Хувьцаа эзэмшигчдийн иргэншил	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Эзэмшиж буй хувьцааны	
				Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Байгууллага	Гадаад	3	4,874,255	6.2%
2		Дотоод	19	328,818	0.42%
3	Иргэн	Гадаад	24	2,112,274	2.68%
4		Дотоод	1045	71,227,654	90.7%
Нийт			1091	78,543,001	100%

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хүснэгт 3

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Иргэн Д.Зоригт	42,530,145	54.15%
2	Иргэн Д.Оюунсүрэн	23,460,015	29.87%
3	"Импера монголиа холдинг" ХХК	4,805,817	6.12%
4	Бусад	7,747,024	9.86%
Нийт хувьцааны тоо		78,543,001	100%

Хувьцаа эзэмшигч Ц.Сүхбаатар: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний зүгээс дээрх тайлантай холбоотой асуух асуулт байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээр гадны компани орж ирсэнд ихээхэн сэтгэл хангалуун байна. Энэ компанийн талаар мэдээлэл байна уу.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Энэ компанийн тухайд гэвэл Туркийн хөрөнгө орулалттай компани байгаа. Манай улсад хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хөрөнгө оруулалтын компани. Тухайн компанийн хувьд жилд 2 удаа бидэнтэй биечлэн уулзаж, санал бодлоо хуваалцдаг.

Хувьцаа эзэмшигч Ц.Сүхбаатар: Аан за баярлалаа. Цаашдын ажилд нь амжилт хүсье.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг тайлангаа үргэлжлүүлэв. ***Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, эзэмшлийн хувь хэмжээний талаар:***

Хүснэгт 4

№	Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог нэр	Эрхэлж буй ажил,	Эзэмшиж буй хувьцааны	
			Тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	Дашзэвэг овогтой Зоригт	Иргэн	42,530,145	54.15
2	Дугаржав овогтой Оюунсүрэн	“Улаанбаатар дахь Америк ерөнхий боловсролын сургууль” ХХК-ийн гүйцэтгэх захирал	23,460,015	29.87
Нийт			65,990,160	84.02

Манай компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь гэр бүлийн гишүүд байдаг бөгөөд одоогоор өөрчлөлт ороогүй байна.

Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар: Манай компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага байдаг. ТУЗ-ийн 9 гишүүдийг компанийн 2021 оны 4-р сарын 9-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас “Компанийн дүрэм”-ийн 7.23-р заалтын дагуу 5 жилийн хугацаатай улируулан сонгосон байна.

“Компанийн засаглалын кодекс”-т нийцүүлэн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээр томилох асуудлыг хэлэлцэж, улмаар хороодын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон.

Хүснэгт 5

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл аудитын хорооны бүрэлдэхүүн		
Дарга	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Н.Мөнхзул	ТУЗ-ийн ердийн гишүүн
Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн		
Дарга	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Д.Оюунсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн
Гишүүн	Д.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн		
Дарга	Н.Батсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Б.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүн	Б.Оюунцэцэг	ТУЗ-ийн ердийн гишүүн

Өнөөдрийн хуралд манай ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Туяа, хараат бус гишүүн Н.Батсайхан, ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн, ердийн гишүүн Н.Мөнхзул, Б.Амарсанаа, Д.Алтанчимэг болон Б.Оюунцэцэг миний бие биечлэн оролцож байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Энэ дашрамд хуралдаа хүрэлцэн ирсэн ТУЗ-ийн гишүүддээ талархал илэрхийлье. Ингээд гүйцэтгэх захирлын тайлантай холбоотойгоор асуух асуулт байна уу. Байхгүй бол тайлангаа үргэлжлүүлэх үү.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул гүйцэтгэх захирал тайлангаа үргэлжлүүлэв.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Асуух асуулт байхгүй гэсэн тул ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой тайланг танилцуулья. Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж, компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, компанийн үйл ажиллагааг зөв зохистой төвшинд хүргэх, компанийн зорилго, зорилтоо биелүүлэхэд Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай чиглэлийг өгч ажиллаж ирсэн. Тайлант хугацаанд манай компанийн ТУЗ нь 3 удаа хуралдаж, 21 асуудал хэлэлцэж, 9 тогтоол шийдвэр гаргаж хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороод нь өөрсдийн хамрах чиг үүргийнхээ хүрээнд хууль, тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн тодорхой асуудлуудаар санал дүгнэлт, зөвлөмж боловсруулж, ТУЗ-д танилцуулан ажиллалаа.

<u>Компанийн хувьцааны үнэ ханш, ногдол ашгийн талаарх мэдээллийг танилцуулья</u>. Манай компанийн хувьцаа 2025 онд Монголын хөрөнгийн бирж дээр 172 өдөр идэвхитэй арилжаалагдаж нийт 694,289 ширхэг буюу 125.1 сая төгрөгийн хувьцаа арилжаалагдсан байна.
Сүүлийн 5 жилийн хувьцааны арилжааны тоон үзүүлэлтийг графикаар харуулав.

График 5



Манай компани нь Монголын Хөрөнгийн Биржийн 2 дугаар ангилалд багтдаг. 2025 оны сүүлийн арилжааны өдөр буюу 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн нэгж хувьцааны хаалтын ханш 195.0 төгрөг байсан бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ 15.3 тэрбум төгрөг болсон.

График 6



"Гермес центр" ХК нь 2014 оноос эхлэн хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашигт нийцүүлэн жилд 2 удаа ногдол ашиг хуваарилж ирсэн. Дараах хүснэгтээр компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн мэдээллийг харуулав

Хүснэгт 7

Ногдол ашиг хуваарилсан огноо		Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (сая төг)	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Ногдол ашиг олгосон хэлбэр		Ногдол ашиг тараалтын хувь
					ҮЦТХТөвөөр зуучлуулан бэлэн бусаар	Компани дээрээс	
2022	Эхний хагас жил	8.02	629.9	1024	90.2	539.7	100%
	Сүүлийн хагас жил	7.50	589.1	1051	84.4	504.7	100%
Нийт		**15.52**	**1219**				
2023	Эхний хагас жил	12.00	942.5	1056	135.0	807.5	100%
	Сүүлийн хагас жил	9.20	722.6	1065	103.5	619.1	100%
Нийт		**21.20**	**1665.1**				
2024	Эхний хагас жил	12.50	981.8	1067	140.6	841.2	100%
	Сүүлийн хагас жил	9.60	754.0	1076	108.0	646.0	100%
Нийт		**22.10**	**1735.80**				
2025	Эхний хагас жил	15.70	1233.1	1085	176.6	1056.5	100%
	Сүүлийн хагас жил	10.69	839.6				
Нийт		**26.39**	**2072.70**				
ХХОАТатвар хасагүй дүн болно.							

Сүүлийн 5 жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдэд тараасан болон нэгж хувьцаанд тараасан ногдол ашгийн мэдээллийг харуулав.

График 7



График 8



Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь тухайн жилүүдэд хуваарилсан ногдол ашгийг компанийн төв байр болон Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 100% тарааж, ногдол ашиг тараалтын тайланг "Компанийн тухай хууль"-ийн 46.14, 46.15 дахь заалтын дагуу ХЭЭХуралд тайлагнаж, улмаар Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.

Компанийн 2026 оны ногдол ашгийн талаар: "Гермес Центр" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2026 онд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, санхүүгийн тайланд жилд 2 удаа аудитын дүгнэлт гаргуулж, ногдол ашгийг оны хагас болон бүтэн жилээр 2 удаа хуваарилах саналтай байгааг хувьцаа эзэмшигчдэдээ дуулгахад таатай байна. Ингээд гүйцэтгэх захирлын зүгээс тайлангаа танилцуулж дууслаа. Асууж тодруулах зүйл байвал чөлөөтэй асууна уу.

Хувьцаа эзэмшигч Р.Лхагвадорж: Сайн байцгаана уу Намайг Р.Лхагвадорж гэдэг. Энэ компанийн хувьцаа эзэмшигч бөгөөд анх удаагаа хуралд оролцож байна. Гүйцэтгэх захирлын тавьсан тайлангуудтай танилцлаа. Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа юм байна гэдгийг ойлголоо. Миний зүгээс нэг асуулт байна. Компани нь ногдол ашгийн бодлоготой юу. Зарим компаниуд жишээ нь "Хаан банк" гэхэд цэвэр ашгийнхаа 60%-ийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараана гэдгээ олон нийтэд зарлачихсан. Танай компанийн тайлан мэдээлэлтэй танилцахад жил бүр ногдол ашгаа 100% тарааж байгаа юм байна. Үүнийгээ бодлого гаргаад явж болохгүй юу. Компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх тал дээр ямар бодолтой байгааг асууя

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Тайлангаа дэлгэрэнгүй танилцуулсан Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэгтээ баярлалаа. Мөн тайланд анхаарлаа хандуулсан хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлж байна. Ингээд таны асуусан асуултанд дараах хариултуудыг өгье.

Манай компанийн тухайд барилгын материалын худалдаа эрхлэгч жижиг дунд бизнес эрхлэгчдэд түрээсийн талбай түрээслэн үйл ажиллагаа явуулж байна. Зөвхөн түрээсийн бизнес эрхэлдэг өөрөөр ямар ч салбарт үйл ажиллагаа явуулдаггүй. Бидний дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд үйл ажиллагаагаа өргөтгөж шинээр худалдааны төв барих ч юм уу ямар нэгэн хөрөнгө оруулалт хийх өргөтгөл хийх бодлого одоогоор байхгүй байна. Учир нь дүүрэг болгонд барилгын материалын худалдааны төвүүд нээгдчихсэн, худалдан авагчид цөөн байгаа энэ цаг үед шинээр худалдааны төв байгуулах, улмаар тухайн талбайг бүрэн дүүрэн дүүргэнэ гэдэг нь өөрөө их эрсдэлтэй байгаа. Энэ асуудлыг бид жил бүр л танилцуулдаг. Манай компанийн зорилго бол тогтвортой үйл ажиллагаа явуулах, мөн эдгээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Та бүхэн мөн тайлангаас компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн талаарх мэдээллийг авсан байх. Миний бие нь нөхөр Д.Зоригтын хамтаар энэ компанийн 84 гаруй хувийг эзэмшиж байгаа. Бидний зүгээс нэмж хувьцаа авах болон зарах сонирхол байхгүй. Энэ компанийг анх авахад санхүүгийн хувьд маш хүндрэлтэй байсан. Тухайн үеийн эрсдэлийг манай гэр бүл бүрэн хариуцсаар өдий хэмжээнд хүргэсэн шүү гэдгийг мөн дахин та бүхэндээ сануулья. Тэгээд ч бидний нас явж байна. Тиймээс манай гэр бүлийн зүгээс дахин эрсдэлтэй алхам хийж өргөтгөх, ямар нэгэн хөрөнгө оруулалт хийх боломж байхгүй гэдгийг хэлье. Мөн түүнчлэн төр засгийн тогтворгүй байдлаас шалтгаалаад олон жилээр төлөвлөх ямар ч боломжгүй байгааг та бүхэн бас мэдэж байгаа. Одоогоор өгч байгаа энэ ногдол ашиг бол хамгийн максимум ашиг гэдгийг хэлэх нь зөв юм байна. Тиймээс та бүхэн өндөр ашгийн хүлээлт бүү үүсгээрэй. Мөн бидний зүгээс одоогоор ажиллаж байгаа 14 ажилтан ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний дэмжлэгийг үзүүлсэн учраас дахин ажиллагсдынхаа нийгмийн асуудалд хөрөнгө оруулалт хийхгүй. Харин дараагийн үе болох ажилтан ажиллагсдынхаа хүүхдүүдийн сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүрийн цэвэр ашгаас бага хэмжээний мөнгийг хуваарилаад, үлдсэн ашгийг 100% хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилна гэсэн бодлого баримталж байна.

Хувьцаа эзэмшигч Г.Гансүх: Хүн бүрийн бодол өөр шүү дээ. Миний хувьд ногдол ашгаа жилд 2 удаа авч байгаадаа сэтгэл хангалуун байдаг. Хэрэвзээ өөр зүйлд хөрөнгө оруулалт хийгээд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй бол бидний жижиг хувьцаа эзэмшигчид хувьцаагаа зараад л явчихна. Тухайн жилийн ашгаа ногдол ашигт хуваарилж байгаад миний хувьд сэтгэл хангалуун байдаг.

Хувьцаа эзэмшигч Ч.Мөнхбаяр: Сайн байцгаана уу. Намайг Ч.Мөнхбаяр гэдэг. Анх удаа хуралд оролцож байна. Компанийн түүхийг сонсох гэсэн юм.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг хувьцаа эзэмшигчийн асуултанд хариулна уу.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Манай компани нь 2003 онд байгуулагдсан бөгөөд 2005 онд Гермес барилгын материалын худалдааны төвийг ашиглалтанд оруулж, улмаар жижиг бизнес эрхлэгч нарт лангуу, павильон түрээслэх замаар түрээсийн орлого олж байна. Компани нь 2008 онд хувьцааныхаа 30 хувийг олон нийтэд санал болгон Монголын Хөрөнгийн бирж дээр арилжаалснаар нээлттэй хувьцаат компани болсон. Тухайн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр 2009 онд Эрдэнэт хотод өөрийн компанийн салбар худалдааны төвийг нээн ажиллуулж эхэлсэн. Эрдэнэт хот дахь салбар худалдааны төв нь анхнаасаа алдагдалтай ажиллаж байсан учраас 2014 онд зарж борлуулсан. Тухайн худалдааны төвийг борлуулсан мөнгөн хөрөнгө нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө учраас шууд ногдол ашиг болгон хуваарилж болохгүй. Тиймээс сар бүр түрээслэгчдээс хураан авч буй түрээсийн төлбөрийн илүүдэл мөнгөтэй нийлүүлж урт болон богино хугацаат хадгаламж хэлбэрээр банкинд хадгалуулж байна. Үр дүнд нь өнгөрсөн 2025 онд гэхэд 500.0 гаруй сая төгрөгийн хүүний орлого олсон. Түүнчлэн манай худалдааны төвийн хувьд зөвхөн түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг учраас түрээсийн төлбөрийг нэмэгдүүлж байж л ашиг, орлогоо нэмэгдүүлэх боломжтой. Сая ТУЗ-ийн даргын хэлсэнчлэн манай компанийн зорилго нь тогтвортой, тасралтгүй байх учраас түрээсийн үнэ тарифын тогтвортой бодлого баримталж ирсэн. Худалдааны төвийн 1м2 талбайн үнэ УБ хотод ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй худалдааны төвүүдтэй харьцуулахад дундаж үнэ байгаа. Өнөөдрийн байдлаар манай худалдааны төвд 202 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд лангуу, павильон, контейнэр, оффисын талбай түрээслэн үйл ажиллагаа явуулж байна. Үнийн тухайд гэвэл:

Павильон – 1м2 – 36,000 төгрөг
Лангуу – 1 ширхэг – 375,000 төгрөг
Контейнэр – 1 ширхэг 200, 000
Оффисын 1м2 – 36,000 төгрөгөөр түрээсэлж байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Би жил жилийн хуралд компанийн үйл ажиллагааг өргөтгөх, улмаар шинээр хөрөнгө оруулалт хийх бодолгүй байгаа тухайгаа хэлж байсан. Тэгээд ч бидэнд тийм бэлэн шинэ төсөл ч алга байна. Бидний дараагийн үе энэ асуудлыг цаашид шийдээд явах байх гэж бодож байна. Одоогоор миний баримталж буй бодлого бол эдгээр жижиг бизнес эрхлэгчдийг энэхүү хэцүү цаг үеийг алдагдалгүй даван туулахад дэмжиж туслах. Тиймээс түрээсийн дарамтанд оруулахгүйн тулд үнэ тарифын тогтвортой бодлогыг баримталж байна. Өөр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул хурлын дэгийн дагуу 2-р асуудлыг Эрсдэл аудитын хорооны дарга Д.Туяа танилцуулна уу.

Хэлэлцсэн 1-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан тэмдэглэв.

Хэлэлцэх 2-р асуудал: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах тухай – элэлцүүлэгч Эрсдэл аудитын хорооны дарга Д.Туяа

Эрсдэл аудитын хорооны дарга Д.Туяа: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хуралд хүрэлцэн ирсэн эрхэм хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие нь тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Эрсдэл аудитын хорооны даргаар ажилладаг.

"Гермес Центр" ХК-ийн 2025 оны эхний болон сүүлийн хагас жилийн санхүүгийн тайланд "Си Эс Ай аудит" ХХК хөндлөнгийн шалгалтыг хийсэн бөгөөд компанийн 2025 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулга нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэсэн дүгнэлтийг гаргасан. ТУЗ-өөс компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд өгсөн дүгнэлтийг та бүхэнд сонордуулья.

"Гермес Центр" ХКомпанийн 2025 оны татварын дараах цэвэр ашиг 2,073.5 сая төгрөг байгаа бөгөөд энэхүү ашгийг төлөвлөгөө 1,919.1 сая төгрөг байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 154,4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Компанийн 2025 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 26 төгрөг 40 мөнгө байгаа бөгөөд ногдол ашгийн төлөвлөгөө 24 төг 43 мөнгө байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 1 төг 97 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан тул гүйцэтгэх удирдлагын багийг 2025 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай сайн ажилласан хэмээн ТУЗ-өөс дүгнэсэн болно.
Хувьцаа эзэмшигч та бүхэн ТУЗ-ийн дүгнэлт болон аудиттай холбоотой асуух асуулт байвал асууна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул дэгийн дагуу хурлаа үргэлжлүүлэв.

Хэлэлцсэн 2-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрч, тогтоолоор батлав.

Хэлэлцэх 3-р асуудал: "Компанийн дүрэм"-д өөрчлөлт оруулах тухай – Хэлэлцүүлэгч хурлын дарга Д.Оюунсүрэн:
Хурлын дарга Д.Оюунсүрэн: Компанийн дүрмэнд дараах өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай байна. Учир нь би та бүхэнд хэлсэнчлэн манай компанийн үйл ажиллагааны хамрах цар хүрээ бага зөвхөн түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, мөн худалдааны төвийн түрээслэгчдийн үйл ажиллагаа тогтворжсон зэргээс шалтгаалан ТУЗ-ийн хурлыг улирал бүр гэхээсээ илүүтэйгээр ногдол ашиг хуваарилахтай холбогдуулан жилд 2 удаа хуралдуулах саналтай байна. Өнгөрсөн 2025 онд гэхэд манай компанийн ТУЗ нь 3 удаа бүрэн бүрэлдэхүүнээр 1 удаа түр хорооны хурал хийсэн. Түр хороо нь ТУЗ-ийн 2 гишүүн болон гүйцэтгэх удирдлагын багийн 2 гишүүнээс бүрдэх бөгөөд хурлаар компанийн 2026 оны төсөв төлөвлөгөө, ажилтан ажиллагсдын орон тоо, цалингийн төсөв, худалдааны төвийн ажил амралтын хуваарь, үнэ тариф зэргийг баталсан. Ингээд явахад надад боломжийн санагдсан. Мөн дүрмэнд орж буй дараагийн нэг өөрчлөлт нь 2014 оноос эхлэн манай компанийн хувьд жилд 2 удаа ногдол ашиг хуваарилж эхэлсэн Монголын хамгийн анхны компани болсон. Тэр ч утгаараа дээрх асуудлыг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, улмаар СЗХорооноос зөвшөөрөл авахаар хүргүүлсэн боловч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуультай нийцэхгүй байна гээд буцаасан. Бид энэ асуудлыг дахин судалж үзэхэд СЗХорооны 2022 оны 03-р сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн 6-р хавсралт болох Ногдол ашгийн бодлогын үлгэрчилсэн журмын 2.2 – т "ТУЗ нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж болно. Энэ

тохиолдолд уг шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба энэ баримт бичгийн 2.1-т заасан нөхцөл хангагдсан байна" гэсэн заалтыг оруулж өгсөн байна. Тиймээс бид ногдол ашигтай холбоотой дүрмийн 10.1 болон 10.3-р заалтуудыг дараах байдлаар өөрчлөн батлуулахаар энэ удаагийн хуралд дахин оруулж байна.

Дүрмийн одоогийн заалт	Дүрмийн өөрчлөлт оруулсны дараах заалт
7.33-р заалт: ТУЗ-ийн *хурлыг улиралд нэг удаа* хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.	ТУЗ-ийн *хурлыг тухайн жилд 2 удаа* хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.
10.1-р заалт: Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг *санхүүгийн бүтэн жил* дуусснаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт хүргүүлнэ.	Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн *хагас болон бүтэн жил* дуусснаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт хүргүүлнэ.
10.3-р заалт: Компанийн *бүтэн жилийн* санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.	Компанийн *хагас болон бүтэн жилийн* санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.

Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигч Р.Лхагвадорж: ТУЗ-ийн хуралтай холбоотой асуудал нь "Компанийн тухай хууль"-нд юу гэж заасан байдаг вэ. Бас нэг ойлгомжгүй асуудал байгаа нь "Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна" гэсэн заалт байгаад энэ эрх үүргийнхээ хүрээнд компанийн дүрмэндээ өөрчлөлт оруулаад баталсан байхад СЗХорооноос зөвшөөрөл авна гээд байгаа асуудлыг ойлгосонгүй ээ.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Манай компанийн ТУЗ-ийн гишүүн хуульч Б.Амарсанаа энэ асуултанд хариулна уу.

ТУЗ-ийн гишүүн Б.Амарсанаа: Компанийн тухай хуулийн 80.1 – д "Компанийн дүрмэнд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно" гэж заасан байгаа. Тиймээс бид компанийн дүрмэндээ тухайн жилд 2 удаа хуралдуулна гээд заагаад өгчихсөн байхад КТХ-ийн холбогдох заалттай нийцнэ гэж үзэж байгаа. Мөн СЗХороо нь зохицуулагч байгууллага учраас тухайн компанийн дүрмэндээ оруулсан өөрчлөлт нь холбогдох хууль тогтоомжинд нийцсэн байна уу үгүй юу гэдэгт хяналт тавьдаг. Манай компанийн хувьд энэ удаагийн дүрмэнд оруулж байгаа дээрх заалтууд нь холбогдох хууль, дүрэм, журамтай нийцэж байгаа учраас бид шинэчилсэн дүрмээ УБЕГазарт бүртгүүлэхэд асуудалгүй гэж харж байна. Бид энэ асуудлыг дараа жилийн хурлаар та бүхэндээ тайлагнаж ажиллах болно.

Хувьцаа эзэмшигч Р.Лхагвадорж: За баярлалаа. Компанийн эрх барих дээд байгууллага нь зөвшөөрөөд баталсан байхад асуудалгүй байхаа.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Асуулт асуусан хувьцаа эзэмшигч Р.Лхагвадорж танд баярлалаа. Мөн хуулийн хүрээнд тайлбар өгсөн гишүүн Б.Амарсанаадаа баярлалаа. Өөр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигч Г.Гансүх: "Гермес Центр" ХК-ийн хувьд жилдээ 2 удаа ногдол ашиг хуваарилж эхэлсэн Монголын анхны компани нь маргашгүй үнэн. Түүний дараагаар АПУ ХК, Хас банк ХК, Сүү ХК, Инновэйшн инвестмент ХК гэх мэтээр үргэлжилсэн. Тэгээд ч энэ асуудалтай холбогдуулаад СЗХороо ногдол ашгийн бодлогын журмаа өөрчилсөн байх. Тиймээс компанийн хувьд энэ асуудлаа дүрмэндээ оруулаад албажуулаад явах нь зөв гэж бодож байна. Баярлалаа

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Хувьцаа эзэмшигч Г.Гансүх танд баярлалаа. Хэлэлцсэн асуудалтай холбоотой өөр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг сайшаан тэмдэглэв.

Хэлэлцсэн 3-р асуудлаар гаргасан шийдвэр: "Компанийн дүрэм"-нд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% дэмжиж, тогтоолоор батлав.

Хэлэлцэх 4-р асуудал: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай – Хэлэлцүүлэгч хурлын дарга Д.Оюунсүрэн:

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Манай компанийн ТУЗ-ийн одоогийн бүтэц бүрэлдэхүүнийг 2021 онд шинэчлэн сонгосон бөгөөд "Компанийн дүрэм"-ийн 7.23-р заалтанд "ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх нь үргэлжилнэ" гэж заасан байгаа. Тиймээс 2026 онд ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх дуусгавар болж байгаа тул дахин шинээр шинэчлэх шаардлага үүссэн. Энэ жилийн хувьд ТУЗ-ийн гишүүдээс Ц.Түвшинжаргал чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн. Тиймээс бид өөрсдийн залгамж халаагаа бэлтгэх зорилгоор хүү З.Оргилыгоо нэр дэвшүүлж байна. Бусад нь хуучин гишүүд байгаа. Ингээд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид өөрсдийгөө танилцуулна уу. Би өөрийгөө танилцуулах шаардлагагүй болов уу гэж бодож байна. та нар намайг бүгд мэдэж байгаа байхаа.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Д.Алтанчимэг: Сайн байцгаан уу. Намайг Дүвчиндорж овогтой Алтанчимэг гэдэг. Нягтлан бодогч мэргэжилтэй. Одоогоор Одод ХХК-д нягтлан бодогчоор ажилладаг. "Гермес Центр"ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2012 оноос эхлэн одоог хүртэл ажиллаж байна.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Б.Оюунцэцэг: Намайг Батсүх овогтой Оюунцэцэг гэдэг. Инженер эдийн засагч, Бизнесийн удирдлагын менежер мэргэжилтэй. 2009 оноос эхлэн тус компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад 2016 оноос эхлэн одоог хүртэл гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Б.Амарсанаа: Намайг Буянцог овогтой Амарсанаа гэдэг. Хуульч мэргэжилтэй. Энэ мэргэжлээрээ банк санхүүгийн байгууллагад 20 гаруй жил хуульчаар ажиллаж байна. Одоогоор "Төрийн банк" ХК-ийн хууль эрхзүй хариуцсан дэд захирлаар ажилладаг. "Гермес Центр"ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оноос эхлэн одоог хүртэл ажиллаж байна.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч З.Оргил: Намайг Зоригт овогтой Оргил гэдэг. 1998 онд төрсөн, АНУ-ын Индиана мужийн Валпараисо их сургуулийг санхүү эдийн засагч мэргэжлээр төгссөн. Одоогоор Геологи уул уурхайн салбарт ажиллаж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Д.Туяа: Намайг Дашцэрэн овогтой Туяа гэдэг. Эдийн засагч мэргэжилтэй. Одоогоор "Төрийн банк" ХК-д хэлтсийн захирлаар ажилладаг. "Гермес Центр"ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2012 оноос эхлэн одоог хүртэл ажиллаж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Н.Батсайхан: Намайг Нямжав овогтой Батсайхан гэдэг. Эдийн засагч мэргэжилтэй. Одоогоор "Монгол даатгал" ХК-ийн Чингэлтэй салбарын захирлаар ажилладаг. "Гермес Центр"ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2012 оноос эхлэн одоог хүртэл ажиллаж байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Нэр дэвшигч гишүүддээ баярлалаа. ТУЗ-ийн 9 гишүүнээс хараат бус гишүүнд нэр дэвшигч Б.Алтангэрэл маань хүндэтгэх шалтгааны улмаас өнөөдрийн хуралд хүрэлцэн ирж чадсангүй. Танилцуулга нь хурлын материалд байгаа тул та бүхэн танилцаарай. Нэр дэвшигчдээс асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигч Г.Гансүх: Дараагийн залгамж үеэ оруулж ирсэнд баяртай байна. Миний хувьд танай компанийн ТУЗ-ийн гишүүдэд сэтгэл хангалуун явдаг. Ихэнх нь эдийн засагч мэргэжилтэй хүмүүс байдаг болохоор итгэдэг. Цаашдын ажилд нь амжилт хүсье.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Хувьцаа эзэмшигч Г.Гансүх танд баярлалаа. Миний хувьд 2 охин 1, хүүтэй. З.Оргил манай бага хүү байгаа. Бидний нас ч явж байна. Тиймээс өөрсдийн залгамж халаагаа бэлтгэх зорилгоор өөрийн хүүгээ компанийн ТУЗ-даа оруулж ирж байна. Цаашдаа компанийхаа өдөр тутмын үйл ажиллагаатай танилцаад, ойлголт авах байх гэж бодож байна. Өөр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг сайшаан тэмдэглэв.

Хэлэлцсэн 4-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 99,87% сайшаан дэмжиж, тогтоолоор батлав.

Хэлэлэх 5-р асуудал: Компанийн 2026 оны зорилтын тухай – Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Манай компани нь 2026 онд дараах зорилго, зорилтыг тавин ажиллаж байна. Үүнд:

№	Агуулга	Дүн	Өмнөх онтой харьцуулбал
1	Нийт орлого	3,676.5 сая ₮	
2	Нийт зардал	1,263.5 сая ₮	
3	Нийт цэвэр ашиг	2,171.5 сая ₮	
4	Нэгж хувьцаанд оногдох ногдол ашиг	27 төг 65 мөн	
5	Ажиллагсдын орон тоо	14	2 орон тоо цөөрүүлсэн

Компанийн 2026 оны зорилттой холбоотойгоор асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигч Ц.Сүхбаатар: Эхний 3 сарын байдлаар орлогын төлөвлөгөө тасарсан уу, хэвийн байгаа юу?

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: 2026 оны эхний 3 сарын байдлаар манай компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Худалдааны төвийн талбай 100% бүрэн түрээслэгдсэн. Түрээслэгчдээс авах түрээсийн төлбөрийг бүрэн авч байна. Дайн, геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй бензин

шатахууны үнийн өсөлт, тээвэр ложистикийн үнийн өсөлт, инфляци, валютын ханшийн өсөлт зэргээс шалтгаалан манай түрээслэгчдийн бизнес ямар болохыг бид таашгүй. Гэхдээ бидний зүгээс дээрх төсөв төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө хичээн ажиллана. Өөр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг сайшаан тэмдэглэв.

Хэлэлцсэн 5-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн 2026 оны зорилтыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан дэмжиж, хурлын тэмдэглэлд оруулав.

Хэлэлцэх 6-р суудал: ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай – Хэлэлцүүлэгч хурлын дарга Д.Оюунсүрэн:

***Хурлын дарга Д.Оюунсүрэн*:** Хурлын дэгийн дагуу компанийн ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийн гүйцэтгэл болон 2026 оны төсвийн тухай танилцуулья.

ТУЗ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэл: Тус компани нь 2025 онд ТУЗ-ийн цалинд 22.9 сая төгрөгийн зардлыг гаргаж олгож ажилласан.

ТУЗ-ийн 2026 оны төсвийн тухай: ТУЗ-ийн хурлыг жилд 2 удаа хуралдуулдаг болохтой холбоотойгоор “Гермес центр” ХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалинг дараах байдлаар олгох саналыг оруулж байна.

№	Албан тушаал	Орон тоо	Нэг удаагийн хурлын цалин		Хурлын тоо	Нийт 2026 оны жилийн цалин
			2025 он	2026 он		
1	ТУЗ-ийн дарга	1	864,000.00	864,000.00	2	1,728,000.00
2	ТУЗ-ийн гишүүд	8	792,000.00	792,000.00	2	12,672,000.00
3	ТУЗ-ийн НБД	1	1,000,000.00	1,000,000.00	2	2,000,000.00
Нийт төсөв		10				16,400,000.00

Жич: ТУЗ-ийн дарга, гишүүд нь хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн цалинг олгох бөгөөд жилд 2 удаа буюу хагас жил тутам хуралдахаар тогтсон. Хуралд ТУЗ-ийн гишүүн ямар нэгэн шалтгаанаар оролцоогүй тохиолдолд цалин олгогдохгүй. Хувьцаа эзэмшигчид та бүхэн саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Хэлэлцсэн 6-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан дэмжиж тогтоолоор батлав.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй бол тооллогын комисс саналын хуудсыг хураан авч нэгтгээд, санал хураалтын нэгдсэн дүнг танилцуулна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлж, тооллогын комисст саналын хуудаснуудаа хураалгав.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хураан авч нэгтгэн тоолоод, санал хураалтын нэгдсэн дүнг хурал зохион байгуулах комисст хүлээлгэн өгөв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дарга О.Энхжаргал: Өнөөдрийн хуралд нийт 67,427,884 саналын эрхтэй 22 хувьцаа эзэмшигчид энгийн болон кумульятив аргаар санал хураах саналын хуудсаар санал өгөх байсан. Тэдгээрээс саналын хуудсаа хураалгаагүй 1 хувьцаа эзэмшигч, мөн кумульятив аргаар санал өгсөн боловч хүчингүй болсон 1 саналын хуудас байлаа. Брокер дилерийн компаниудаас саналын хуудас ирүүлээгүй. Ингээд дээрх саналын хуудаснуудын нэгдсэн дүнг танилцуулья. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 99.88% зөвшөөрсөн тул тогтоолын төслийг батлав.
2. “Компанийн дүрэм”-д өөрчлөлт оруулах тухай асуудлыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 99.88% зөвшөөрсөн тул тогтоолын төслийг батлав.
3. Компанийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 99.88% зөвшөөрсөн тул тогтоолын төслийг батлав.
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн сонгох тухай асуудлыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 99.87% зөвшөөрсөн тул тогтоолын төслийг батлав

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт, санал хүсэлт байхгүй бол хурлын дэгийн дагуу өнөөдрийн хурлыг өндөрлөснийг мэдэгдэж байна. Энэ удаагийн хурлаар хэлэлцсэн асуудлын тогтоолын төслүүд саналын хуудасны дүнгээр баталгаажна. Бидний ажлыг ойлгож, хүндэтгэн хуралдаа идэвхитэй оролцдог хувьцаа эзэмшигчдэдээ гүнээ талархал илэрхийлье. Баярлалаа баяртай. Дараа жилийн ээлжит хурлаар дахин уулзацгаая.

“Гермес центр”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт 2 цаг гаруй үргэлжилж, 17 цаг 19 минутанд дуусав. Хурал амжилттай болж өнгөрлөө.

УЛААНБААТАР ХОТ
ГЕРМЕСЦЕНТР ХК
ТТБ1437 ... 2773678

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

_____ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

Хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:

_____ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэсүрэн